

ТҮҮХИЙ УСНЫ НӨЛӨӨ

Байгалийн (түүхий) ус гэж цэвэршүүлээгүй, шүүгээгүй, боловсруулаагүй газар доорх ус, борооны буюу хөрсний ус, нуур цөөрөм, булаг шанд, гол мөрний усыг хэлнэ.

Хэрэглэгчид савласан усыг боловсруулсан, крантны усыг цэвэршүүлсэн учраас эрдэсгүй болж усны амт, үнэр өөрчлөгддөг гэж үздэг. Тиймээс байгалийн усыг илүү өвөрмөц амттай, олон төрлийн ашиг тустай хэмээн ойлгодог.

Сүүлийн хэдхэн жилд байгалийн ус хэрэглэгчид ихээр бий болсон шалтгаан нь “Органик хүнс” нэртэй хөдөлгөөн гарч органик бүтээгдэхүүнийг хамгийн эрүүл бөгөөд хүний эрүүл мэндэд нэн чухал гэдгийг баталсантай холбоотой юм.

Байгалийн усанд агуулагдах эрдсүүд түгээгүүрийн түүхий ус болон савалгаатай уснаас хэд дахин илүү гэж ихэнх хэрэглэгчид үздэг. Тийм учраас усыг шүүлгүй, химийн ямар нэг аргаар ариутгалгүй хэрэглэх явдал эрүүл мэндэд ихээхэн ач тустай гэдэгт тэд итгэдэг байна.

Эрдэс бодис

Байгалийн ус нь эрдэс бодисоор баялаг. Харин савласан цэвэр усан дахь эрдэс бодисын хэмжээ хангалтгүй буюу байх ёстой хэмжээнээсээ бага байдаг. Хэрэглэгчдийн үзэж байгаагаар ус цэвэршүүлэхэд ашиглаж байгаа шүүлтүүрүүд усанд агуулагддаг ашигтай эрдсүүдийг алга болгодог. Тийм учраас эрдэс бодис бүхий байгалийн усыг хэрэглэх нь хүний эрүүл мэндэд сайнаар нөлөөлнө гэж ихэнх хэрэглэгчид үздэг байна.

Нийтийн түгээгүүрийн ус хэрэглэгчид фторын агууламжийг анхаарч үзэх нь чухал. Учир нь усыг фторжуулах нь биед дутагдаж байгаа фторыг нөхөх ач тустай хэдий ч кальцийг биеэс гадагшлуулахад нөлөөлдөгийг анхаарах нь зүйтэй. Тухайлбал, Америкийн Нэгдсэн Улс 1945 оноос ундныхаа усыг фторжуулжээ. Гэвч зарим тохиолдолд фторын илүүдэл хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж уснаас шалтгаалсан шүд цоорох өвчлөлийг нэмэгдүүлдэг учир ундны усанд агуулагдах фторын зохимжтой хэмжээг хянах хэрэгтэй байдаг.

Шүлтлэг чанар

Байгалийн ус шүлтлэг шинж чанартай учраас эрүүл мэндэд чухал ач холбогдолтой гэж ихэнх хэрэглэгчид үздэг байна. Түүхий ус уухын сайн тал нь хүний бие дэх хүчиллэг бодисуудыг саармагжуулах явдал юм. Цэвэршүүлсэн ундны устай харьцуулахад шүлтлэг усанд рН үзүүлэлт өндөр байдаг. Ер нь хүчиллэг чанар өвчний эх үүсвэр болдог төдийгүй, ялангуяа ходоод гэдэс, арьсанд муугаар нөлөөлдөг.

Ашигтай бактериуд

Байгалийн ус нь ашигтай бактериудыг өөртөө агуулдаг. Бактерийн бохирдлын түвшин дэлхийн улс орон, газар нутаг бүрт өөр өөр байна. Харин зарим улс оронд газар доорх усыг цэвэршүүлж хэрэглэх шаардлагагүй аж. Тухайлбал, Исланд улсын гүний ус эрүүл ахуйн шаардлагад тохирдог учраас шууд уухад тохиромжтой байх жишээтэй.

Гэвч байгалийн ус гаднаасаа цэвэр тунгалаг харагдаж байгаа хэдий ч нян бактери, бохирдолтой байх магадлалтай. Тийм учраас Та ууж буй усаа лабораторит шинжлүүлж, шалгаж байх хэрэгтэй.